



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат  
бус гишүүнийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Даваанямын Нэмэхбаяр нь Өвөрхангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 2024/ШЦТ/51 дүгээр шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрхийг 4 жилийн хугацаагаар хасах ялаар шийтгэгдсэн байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хараат бус гишүүнийг хууль, тогтоомж, журмын дагуу сонгон шалгаруулахыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ